*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ХАМРАЛТ ОРЛОГО, ШИМТГЭЛИЙН ӨР ХАРИУЦСАН БАЙЦААГЧ /01.01-05.31/
М.ЭНХЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ***Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх, өр авлага барагдуулах, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх,*** | | | | | | | |
| 1. | Ажил олгогчийн Нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлүүлж, орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах, | Орлогын төлөвлөгөөний хувь | | | 2025 оны хагас жилийн байдлаар Нийгмийн даатгалын шимтгэлд 20,872.3 сая төгрөг төвлөрүүлэхээс байгуулсан шимтгэлд 20,413.3 сая төгрөгийн орлогыг санд төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 97.8 хувь биелүүлсэн байна. | 2025.01.01 - 2025.05.31 | 97.8% |
| 2. | 1.2. Цахим хэлбэрээр ирүүлсэн ажил олгогчийн шимтгэл төлөлтийн (НД-7; НД-8) тайланг цаасан тайлантай тулган баталгаажуулах, | Тайлан хүлээн авалтын хувь | Цахимаар илгээсэн тайлангийн хувь | Илгэсэн тайланг 100% хүлээн авсан байна | “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 3.9-д заасан шимтгэл төлөлтийн тайлан ирүүлэх хугацааг баримтлан аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл төлөлтийн сар бүрийн тайлангийн эхний болон эцсийн үлдэгдлийг хянан шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авч ажиллаа. Хагас жилийн байдлаар<br>• Баянтүмэн сум – 31<br>• Дашбалбар сум- 33 | 2025.01.01 - 2025.05.31 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | • Хөлөнбуйр сум – 18<br>• Халхгол сум – 36<br>• Цагаан-Овоо сум – 38<br>• Сэргэлэн сум - 15<br>• Чойбалсан сум – 19<br>• Хэрлэн сум - 442<br>Байгууллага буюу нийт 632 аж ахуйн нэгж байгууллагын шимтгэл ногдуулалтын тайланг сар бүр хүлээн авч хянан баталгаажуулсан. | | |
| 3. | 3.1. Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 30-аас доошгүй хувиар бууруулах | Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 1883.0 сая төгрөгт хүрсэн. | Оны эхний үлдэгдэлээс 30 хувиар буурсан байх | 2024 оны жилийн эцсээр нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага үүсгэсэн 258 аж ахуйн нэгж байгууллагын 1,883.1 сая төгрөг байснаас 200 аж ахуйн нэгж байгууллагын 761.3 сая төгрөгийг барагдуулсан байна. Өмнөх оны өртэй 58 байгууллагын 1,121.7 сая төгрөг үлдэж барагдуулалт 40.4 хувьтай барагдуулсан байна.<br><br>Эдгээр оны эхний өр авлагыг барагдуулахад шимтгэлийн өр, хариуцсан байцаагчид байгууллагуудын өр авлагын үлдэгдлүүдийг шүүн гаргах болон холбогдох байгууллагын хаяг, захирал нягтлан бодогчийн утсаны дугаар, хүлээн авч баталгаажуулсан НД7, НД8 тайлан, байгууллагын гэрчилгээний хуулбар зэрэг шүүхийн байгууллагад өгөхөд шаардлагатай хавсралт нотлох баримтуудыг гарган өгч мэдээллээ солилцон хамтран ажилласан байна. | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 40.4 |
| 4. | 4.1. Төсөвт байгууллага шимтгэлийн өрийг бүрэн барагдуулах | Шимтгэлийн өргүй гарсан байх. | Төсөвт 16 байгууллагын шимтгэлийн өр 72 сая төгрөг | Төсөвт байгууллагаын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж | Төсөвт байгууллагын оны эхний үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна. Харин сонгуулийн хэсгийн хороо дахин сонгууль болтол үйл ажиллагаа нь явагдахгүй байгаа учир оны эхний үлдэгдэл 761.0 мянган төгрөгийн авлаг | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах. | баргдаагүй үлдсэн байна. /Нөхөн сонгуулийн үйл ажиллагаа явагдахад уг авлагыг барагдуулахаар төлөвлөөд байна/<br><br>- 2024 оны хуримтлагдсан өр авлагыг байргадуулах, 2025 онд шинээр өр үүсгэхгүй ажиллах, мөн нийгмийн даатгалын НД-7, НД-8 тайланг хуулийн хугацаанд ирүүлэх, ирүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагын талаар мөн даатгуулагчийн ажил мэргэжлийн код, шимтгэлийн хувь хэмжээг зөв тооцож илгээж байх тухай албан тоот боловсруулан газрын даргаар батлуулж аймгийн төсөвт байгууллагууд болон нийт аж ахуйн нэгжүүдийн дарга, эрхлэгч нягтлан бодогч нарт аймгийн төрийн сан, сумдын байцаагч нараар дамжуулан хүргэж цаашид анхаарах зөвлөмж хүргэж ажилласан. | | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| 1. | 2.1. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаа явуулах, шийдвэрлэх | - | - | - | Хагас жилийн байдлаар хуулийн хугацаанд тайлангаа илгээгээгүй 200 гаруй аж ахуй нэгжтэй утсаар холбогдон хуулийн хугацаанд илгээх талаар мэдээлэл хүргэн ажилласан.<br><br>Мөн тайлангаа хуулийн хугацаанд илгээгээгүй 22 аж, ахуй нэгжид зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэн 5,500.0 мянган төгрөгийн шимтгэлийн торгуулийн арга хэмжээ авч хүргүүлэн ажилласан байна. | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | 2.2. Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо | 2024 онд 1034 ажил олгогч, 19132 хүнийг албан журмын даатгалд хамруулсан байна. | Ажил олгогчийн тоог шинээр 81, даатгуулагчийн тоог шинээр 395 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлэх /хэлтсийн төлөвлөгөө/ | Хагас жилийн байдлаар шинээр бүртгүүлэхээр хүсэлт гаргасан 42 ажил олгогч байгууллагын 92 даатгуулагчийн мэдээллийг бүртгэж ажиллалаа. Шинээр ажил олгогчоор бүртгүүлж байгаа аж ахуйн нэгжийн захирал, дарга нарын мэдээллийг Улсын бүртгэлийн баазаас татагдаж байгаа мэдээлэлтэй тулган, шалгаж зөрүүтэй мэдээллийг шинэчлэн мэдээллийн санг үнэн зөв бүрдүүлэн ажилласан.<br><br>Шинээр байгуулагдаж байгаа аж, ахуй нэгийн нягтлан бодогч нарт тухай бүр **portal.ndaatgal.mn** сайтад нэвтрэн орж шимтгэлийн тайланг илгээх зааварчилгааг тухай бүрд зааж мэдээлэл өгч ажилласан. | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 50 |
| 3. | 2.3. Мэдээллийн санд бүртгэлтэй ажил олгогчийн захирал, нягтлан бодогчийн харилцах утас, байгууллагын хаяг, утас харилцагч банкны мэдээлэл, үйл ажиллагааны чиглэл зэрэг холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэх | Мэдээллийн сангийн шинэчлэлтийн үнэн зөв байдал | 12 | | Ажил олгогч байгууллагын удирдлага, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан, банкны дансны мэдээллийг сикос системд оруулж, **/portal.ndaatgal.mn/-д** нэвтрэх эрх олгон ажиллав мөн мэдээллээ солиулах болон шинэчлэх хүсэлтийн дагуу 72 аж, ахуйн нэгжийн мэдээллийг баримттай нь тулган Сикос системд шинэчлэн оруулж, мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хангаж ажиллаа. | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 100 |
| ***Гурав 3. Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах.*** | | | | | | | |
| 1. | 3.1 Төрийн жинхэнэ албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж, шаардлагатай | Хэрэгжүүлж ажилласан эсэх | Хуулийн хугацаа | Холбогдох хууль Тогтоомжийн дагуу | Хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн. Ажлын байрны чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотой https://meduuleg.iaac.mn/AOS/Login | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тохиолдолд ХАСХОМ гаргаж хэвших. | | | хийсэн байна. | системд албан тушаалын өөрчлөлттэй холбоотой цаг үеийн мэдээллийг цахимаар оруулж баталгаажуулсан | | |
| 2. | 3.2. Албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах, бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу жилийн эцэст архивд хүлээлгэн өгөх; Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах | Хэрэгжүүлж ажилласан эсэх | 2024 онд сайн дурын даатгалын гэрээг 6 хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн | Холбогдох хууль тогтоомжийн дагуу чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, дүрмийг мөрдөн баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу ангилж 38 ширхэг хадгаламжийн нэгж бүрдүүлэн хуулийн хугацаанд архивд хүлээлгэн өгч ажиллалаа.<br>Авлигын эсрэг хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг дагуу ёс зүйн ямар нэгэн зөрчил дутагдал гаргалгүй ажиллаж байна. | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 100 |
| 3. | 3.3. "CALL PRO" үйлчилгээгээр хандсан иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, | Хэрэгжүүлж ажилласан эсэх | | Тухай бүр гүйцэтгэж, шаардлагатай тохиолдолд ажил орлон гүйцэтгэсэн байна. | Байгууллагын лавлах утасны "CALL PRO" үйлчилгээгээр ирж буй дуудлага бүрд хариу өгч ажиллаж байна. Өдөрт энгийн үед 10-15 дуудлага, Ажил олгогчийн тайлан илгээх хугацааны өдрүүдэд ачаалал нэмэгдэн өдөрт 20-35 дуудлагад тогтмол хариу мэдээлэл өгч байна.<br>"CALL PRO" үйлчилгээгээр ирж буй дуудлагуудын асуултыг дурдвал шимтгэл төлөх дансны дугаар болон банкнууд IBAN дансны дугаарлалттай болсонтой холбоотой IBAN дугаарыг лавлах, мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан шимтгэл төлөх хувь хэмжээ байгууллагын регистрийн дугаараа буруу бичиж шимтгэлээ төлснөөс гарсан алдаанууд залруулах, нягтлан бодогч нар | 2025.01.01<br>-<br>2025.05.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даатгуулагчийн төрөл буруу тайлагнасан алдаа залруулах талаар зэрэг асуултууд дийлэнх хувийг эзэлж байна. | | |
| | | | | | | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Удирдлагаас болон цаг үеийн шинжтэй өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнах | Хэрэгжүүлж ажилласан эсэх | - | - | - Нийгмийн даатгалын шинэчилсэн систем болох Сикос програмд 2024 оны тэтгэврийн тайлан гаргахтай холбогдуулан 3,4,5 сарын нийт 176 тэтгэвэр авагчын олголтын хувиар үүсгэж ажилласан.<br>- 2024 оны | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаарх мэдлэгээ дээшлүүлэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдах, | Сургалтад хамрагдсан тоо | 8 | Сургалтад хамрагдсан байна. | НДЕГ-с 7 хоног бүр цахимаар зохион байгуулдаг “Стрессийг зохицуулахад таны оролцоо”, “Бүтээмжээ нэмэгдүүлэх нь” сургалт,<br>Мөн НДЕГ-аас цахимаар зохион байгуулсан “Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр комиссар Р.Төрбулаг, “Авлигын гэмт | 2025.01.01-2025.05.31 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэг, түүний ойлголт" сэдвээр комиссар М.Жамъяачойжил нарын сургалт зэрэг сургалтуудад хамрагдсан. АЗДГ-аас танхимаар зохион байгуулсан "Хүний хандлаг, сэтгэлгээ өөрчлөх хэрэгцээ шаардлага" сэдэвт 18БЦ сургалтад тус тус хамрагдаад байна. | | |
| 2 | Төрийн албан хаагчийн болон Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд санаачлагатай хандах | Сургалтад хамрагдсан тоо | 21БЦ | Сургалтад хамрагдсан байна. | Төийн албан хаагчийн болон байцаагчийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, хууль тогтоомжийн мэдлэг чадвараа дээшлүүлэх үүднээс МУИС-ийн хууль зүйн сургуулийн эчнээ хөтөлбөрт хамрагдан 2 дугаар дамжаагаа амжилттай дүүргээд байна. | 2024.01.01-2024.12.30 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
*( Албан тушаал )*

.................................. / М.Энхцэцэг /
*( Нэр, гарын үсэг )*

2025.06.09
*( Огноо )*